

БАТЛАВ
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА
Э.БАТТУЛГА

2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр

“ГЕНЕТИК НӨӨЦ, ГЕНЕТИК НӨӨЦТЭЙ ХОЛБООТОЙ УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГИЙН
МЭДЭЭЛЛИЙН САН БОЛОН УГ САНГИЙН АШИГЛАЛТЫН ЦАХИМ БҮРТГЭЛИЙН
МЭДЭЭЛЛИЙН САНГ БИЙ БОЛГОХ” ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны дугаар сарын-ны өдөр

Улаанбаатар хот

1	Үндэслэл	<p>Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр БОУАӨЯ, ХХААХҮЯ, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн газартай хамтран хэрэгжүүлж буй "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь" төсөл нь Саян, Хангайн уулс болон өмнийн говийн бүс нутагт бэлчээр, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх, БОЯБ-ыг хамгаалах, экосистемийн үйлчилгээг сайжруулах үндсэн зорилготой.</p> <p>Тус төсөл нь Бөхөн шарын нуруунд хамаарах Архангай аймгийн Батцэнгэл, Өлзийт, Хайрхан, Эрдэнэмандал сум, Тарвагатайн нуруунд хамаарах Завхан аймгийн Их-Уул, Тосонцэнгэл сум, Зармангийн говь, Улаан шалын хоолойд хамаарах Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Баянцагаан, Баацагаан, Шинэжинст сум болон Говь-Алтай аймгийн Цогт, Чандмань, Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт 7 жилийн хугацаанд (2019-2025) хэрэгжинэ.</p> <p>Төслийн зорилт буюу 4 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд экосистемийн үйлчилгээ, БОЯБ-ын хамгаалал, бэлчээр, ой, ТХГН-ийн менежменттэй холбоотой эрх зүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, ногоон хөгжилд хүрэх арга замыг хөгжлийн дунд болон богино хугацааны төлөвлөлтөд ашиглах, байгалийн баялаг ашигласны төлбөрийг зохистой зарцуулах, ялангуяа ЭСҮ-ний төлбөрийн шинэлэг механизм турших, Монгол Улсад болон олон улсад нэн ховордсон, устах аюулд өртөж буй ургамал, амьтдыг хамгаалах орон нутгийн чадавхыг дээшлүүлэх, нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих замаар биологийн олон янз байдлыг хамгаалах, төр - хувийн хэвшлийн түншлэгийг бэхжүүлэх зэрэг арга хэмжээг төслийн үндсэн баримт бичигт заасны дагуу хэрэгжүүлж байна.</p> <p>Төслийн хэрэгжилтийн гол үр дүн нь зорилтот нутгийн бэлчээр, ой, БОЯБ нөхөн сэргээгдэж, хамгаалалттай газар нутгийн сүлжээ нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд 0.94 сая га талбайгаар нэмэгдэн бэхжиж, 300,000 га бэлчээр, 20,000 га сэрүүн бүсийн ой, 25,000 га заган ойн доройтол буурч, устах аюулд өртөөд буй БОЯБ-нд учрах аюул занал буурсан байх юм. Ялангуяа бэлчээр ашиглагчид болон ойн нөхөрлөлүүдийн чадавхыг бэхжүүлэх, малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэх, ойн зохистой ашиглалт, нэмүү</p>
---	----------	---

өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, малчдын орлого нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлснээр олон нийтэд түшиглэсэн бүлгүүд бэхжиж, нутгийн иргэдийн амьжиргаа илүү тогтвортой болж, төр-хувийн хэвшлийн түншлэл өргөжин, ногоон хөгжлийн арга замын талаарх олон нийтийн ойлголт нэмэгдсэн байх юм (www.ensure.mn).

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасны дагуу байгалийн нөөцийн хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээлт, цаг агаар, уур амьсгал, байгаль орчны бохирдол, өөрчлөлтийн төлөв байдал, байгаль орчны эрх зүйн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар мэдээллийг Байгаль орчны мэдээллийн (<https://eic.mn>) сангаар дамжуулж олон нийтэд нээлттэй хүргэдэг.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Байгаль орчны мэдээллийн санг 2010 оноос эхлэн үе шаттайгаар хөгжүүлж одоогоор 23 мэдээллийн сангаар дамжуулан мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэж байгаа бөгөөд мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, түгээх үйл ажиллагаа, техник технологи нь мэдээлэл, харилцаа холбоо, технологийн төрийн нэгдсэн бодлоготой уялдсан байдаг.

Монгол Улс Биологийн янз байдлын тухай конвенц болон генетик нөөцийн ашиглалтаас үүдэх үр шимийг цударга, эрх тэгш харилцан хүртэх тухай Нагояагийн протоколд нэгдэн орсноор генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг хэрхэн олж авах, ашиглах, үр шимийг харилцан хүртэх талаар үндэсний хууль тогтоомжийг бий болгох, энэ төрлийн бүх мэдээллийг ил тод нээлттэй байлгах үүрэг хүлээсэн билээ.

Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг бүртгэх, хадгалах, хамгаалах, судлан хөгжүүлэх, ашиглах, үр шимийг хүртэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2021 онд Генетик нөөцийн тухай хууль батлагдаж генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн сантай байхаар заасан.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн Мэдээллийн сангийн бүрдэлд “Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн сан” бүрдүүлэхээр 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан.

Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн сан нь 1) генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн мэдээллийн сан; 2) генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн ашиглалтын цахим бүртгэл; 3) генийн сангийн тоон өгөгдлийн сан; 4) холбогдох бусад мэдээллээс бүрдэнэ.

Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн ашиглалтын цахим бүртгэл нь олон улсын мэдээлэл солилцооны төвтэй холбогдохоор хуульд заасан.

Мэдээллийн сангийн технологи, программ хангамжийн агуулга, нэр төрөл, хамрах хүрээг судалгаа шинжилгээ,


		<p>хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан байгуулж мэдээллийг тогтмол шинэчлэн баяжуулж байх шаардлагатай.</p> <p>Хууль эрх зүйн шинэчлэлтэй холбоотойгоор Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн сан болон уг сангийн ашиглалтын цахим бүртгэлийн системийг шинээр хөгжүүлж мэдээ, мэдээллээр баяжуулах шаардлагатай байна.</p>
2	Зорилго	<p>Байгаль орчны мэдээллийн сан дахь Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн санд Генетик нөөц, генетик нөөцтэй холбсотой уламжлалт мэдлэгийн сан болон уг сангийн ашиглалтын цахим бүртгэлийн системийг шинээр бий болгож, мэдээллийн бааз үүсгэхэд ажлын зорилго оршино.</p>
3	Ажил гүйцэтгэх хугацаа	<p>Ажлыг гэрээ байгуулсан өдрөөс хойш 4 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ.</p>
4	Гүйцэтгэх ажил	<p>Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн сан болон уг сангийн ашиглалтын цахим бүртгэлийн системийг хөгжүүлэх дор дурдсан ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Мэдээллийн санг шинээр хөгжүүлэх талаар судалгаа хийж холбогдох хууль эрх зүйн баримт бичиг болон бусад материалтай танилцах; • Мэдээллийн санг шинээр хөгжүүлэхэд ашиглах мэдээллийн технологийн шийдэл болон программ хангамжийг судлах; • Мэдээллийг олон нийтэд ойлгомжтой, илүү хүртээмжтэй болгох талаар судалж шийдлийг боловсруулах; • Системийн өнөөгийн байдлыг тодорхойлон, системийн шинжилгээ хийх; • Мэдээллийн баазын бүтцийг тодорхойлж, өгөгдлийн сангийн тайлбар толь бичиг бэлтгэх; • Мэдээллийн системийг бусад системүүдтэй хэрхэн холбогдох чиглэлээр судалгаа хийж, танилцуулга бэлтгэх; • Шаардлагатай зарим үзүүлэлтийг бар код бүхий загвараар гаргах; • Системийн ерөнхий архитектурыг гаргах; • Шинэ системийн өгөгдлийн сангийн бүтцийн диаграмм, зураглалыг боловсруулах ; • Шинэ системийн UI/UX тодорхойлох; • Front end ба Back end хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэх; • Шинэ системийн туршилтын үйл ажиллагааг үе шаттайгаар хийж гүйцэтгэх; • Шинэ системд оруулах мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу бэлтгэн, мэдээллийн санд бүртгэх, системийн нэвтрүүлэлтийн ажилд дэмжлэг үзүүлж ажиллах; • Системийн админ түвшний болон хэрэглэгчийн гарын авлага бэлтгэх, холбогдох сургалтыг зохион байгуулах; • Системийг хүлээлгэн өгснөөс хойш 6 сарын хугацаанд баталгаат засварын гэрээг байгуулан ажиллах ба түүнээс хойш 3 жил хүртэл хугацаанд үйлчилгээний төлбөр авах гэрээ байгуулан ажиллах.

5	Тайлагналт	<p>Явцын тайлан: Ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаас 2 сарын дотор явцын тайланг гэрээ байгуулагч талд хүргүүлсэн байна;</p> <p>Эцсийн тайлан: Ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулснаас 2 сарын дотор эцсийн тайланг ирүүлсэн байна.</p>
6	Ажил гүйцэтгэгчид тавигдах шаардлага	<p>Ажил гүйцэтгэх баг нь 10-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх ба мэдээллийн технологийн чиглэлээр ажилладаг, мэдээллийн сангийн программ хангамжийг хөгжүүлсэн туршлагатай баг байна.</p> <p><u>Байгууллагад тавигдах шаардлага:</u></p> <ul style="list-style-type: none"> • Ажил гүйцэтгэх байгууллага нь 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай хуулийн этгээд байх ба 10-аас доошгүй орон тооны мэргэжлийн зөвлөхүүдтэй байх; • Зөвлөх үйлчилгээний өдөр тутмын ажил болон тус ажлыг хянан хариуцан ажиллах мэргэжилтэнтэй байх; • Мэдээллийн технологийн чиглэлээр ажилладаг, мэдээллийн сангийн программ хангамжийг хөгжүүлсэн туршлагатай байх ба байгууллага, зөвлөхүүд нь дараах шаардлагыг хангасан байна <p>Үүнд:</p> <p><u>Зөвлөх багт тавигдах шаардлага:</u></p> <p>Багийн бүрэлдэхүүнд дараах мэргэжилтнүүд байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Багийн ахлагч; - Системийн архитектур; - Төслийн менежер; - Хөгжүүлэгч 4-оос доошгүй; - UI/UX дизайнер; - Программын туршигч; - Байгаль орчны мэргэжилтэн. <ul style="list-style-type: none"> • Багийн ахлагч нь мэдээллийн технологийн мэргэжилтэй, мэргэжлээрээ 12-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх; <p>Гишүүд нь:</p> <ul style="list-style-type: none"> • Мэдээллийн системийг хөгжүүлэх программ хангамжийг (Postgresql, Geomoose, React, PHP гэх мэт) бүрэн эзэмшсэн, тухайн чиглэлээр 5-аас дээш жил ажилласан туршлагатай байх; • Мэдээллийн баазыг загварчлах, өгөгдлийн сангийн бүтцийг тодорхойлж, мэдээллийн сангийн тайлбар бичиг боловсруулах туршлагатай байх; • Мэдээллийн сангийн загварт үндэслэн программ хангамжийг хөгжүүлэх чиглэлээр мэдээллийн технологийн мэдлэг, туршлагатай байх; • Газарзүйн мэдээллийн системийн программ (QGIS, ArcGIS, PostGIS, Geomoose) дээр ажиллах болон газарзүйн

		<p>мэдээллийг мэдээллийн санд оруулах дадлага туршлагатай байх;</p> <ul style="list-style-type: none"> • Өгөгдөл, мэдээллийг мэдээллийн санд оруулах, мэдээллийн сангаас мэдээ гаргах зэрэг өгөгдлийн сантай ажиллаж мэдээлэл боловсруулах туршлагатай байх; • Байгаль орчны болон газарзүйн мэдээллийн системийн чиглэлээр мэргэшсэн дадлага туршлагатай ажилтантай байх; • Харилцааны өндөр мэдлэгтэй, захиалагч талын багтай хамтран ажиллаж ойлголцох ур чадвартай байх
7	Захиалагч байгууллага	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон НҮБХХ-ийн "Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь" төсөл
8	Хүрэх үр дүн	<ul style="list-style-type: none"> • Монгол орны Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн сан болон уг сангийн ашиглалтын цахим бүртгэлийн системийг шинээр хөгжүүлсэн байна
9	Хүлээн авах материал	<ul style="list-style-type: none"> • Шинээр хөгжүүлсэн Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн сан болон уг сангийн ашиглалтын цахим бүртгэлийн системийн программ хангамж; • Шинэ системийн мэдээллийн сан; • Системийн гарын авлага; • Гүйцэтгэсэн ажлын явцын болон эцсийн тайлан.
10	Санхүүжилтийн эх үүсвэр	НҮБХХ-ийн "Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь" төсөл
11	Санхүүжилт	Энэхүү ажлыг гүйцэтгэх зардал 69,000,000 (жаран есэн сая) төгрөг болно. Үүнд ажил гүйцэтгэгчийн ажлын хөлс, ногдож болох аливаа татвар, хураамж, шимтгэл бүгд багтана.

ТАНИЛЦСАН:

БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГА



Ц.УРАНЧИМЭГ

2024 оны 08 дугаар сарын-ны өдөр

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ДЭЛГЭРБАТ

2024 оны 08 дугаар сарын-ны өдөр

ХЯНАСАН:
ХУУЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Т.ЭНХЗАЯА

2024 оны 08 дугаар сарын-ны өдөр

БОЛОВСРУУЛСАН:
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



П.САЙНБИЛЭГ